



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 0140

Улаанбаатар хот

Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх зорилгоор хамрах хүрээ, бодлого, үүрэг хариуцлагыг батлах тухай

Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээг нэгдүгээр хавсралтаар, Чанарын менежментийн тогтолцооны бодлогыг хоёрдугаар хавсралтаар, албан хаагчдын гүйцэтгэх үүрэг хариуцлагыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Чанарын менежментийн тогтолцооны явц, хэрэгжилт, үр дүнгийн талаар тухай бүр мэдээллээр хангаж, цаашид тасралтгүй хэрэгжүүлж ажиллахыг Ажлын хэсэгт даалгасугай.

3. Эмч, эмнэлгийн ажилтнуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг албан тушаалын тодорхойлолтонд тусгахыг Хүний нөөцийн менежер /Л.Алдармаа/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа хариуцсан ажлын албаны дарга /П.Ундармаа/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ *Т. Энхзаяа* Т.ЭНХЗАЯА

